



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/198

Мандалговь

Малд үзлэг ангилалт, хянан  
баталгаажуулалт хийх тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8, Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.2.1.1, 3.2.4.2 дахь заалт, Аймгийн засаг дарга, ХХААХҮЯ-ны сайдтай 2017 онд хамтран ажиллах гэрээний 17 дугаар заалт, МЭҮГазрын Даргын А/21-тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан, Адаацаг, Эрдэнэдалай, Говь-Угтаал сумдын нутгийн хонин сүрэгт хавсралтад заасны дагуу үзлэг ангилалт хийж, хээлтүүлэгч шинээр нөхөн тавих, баталгаажуулах, бүртгэлжүүлэх ажлыг 2017 оны 06 сарын 07-ноос 2017 оны 10 сарын 01-ны дотор зохион байгуулж, тайланг Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг сумдын Засаг дарга /Р.Мөнхтогтох, Ж.Батхөлөг, Б.Доржсүмбэр, С.Мөнхбаатар/ нарт даалгасугай.

Хоёр. Үзлэг ангилалт, хянан баталгаажуулалтын ажлыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар /Б.Мөнхжаргал/, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200584